

АӨСҮТ, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Эрүүл мэндийн яам

2022 оны жилийн эцэс

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц
МУ-ын хууль				
	3	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012-12-20 Дугаар 2012.12.20	10.2. Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /10.1.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах/;	Тус төв нь хүнсний бараа бүтээгдэхүүний нийлүүлдэг компанийг төндэрээр сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажилласан ба гэрээний дагуу хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтад хяналт тавьж ажиллаж байна. Хоол үйлдвэрлэл тасаг руу урсгалын дагуу ордог ба гадны хүн оруулдаггүй. Тогооч болон үйлчлэгч нарыг тогтмол /6 сар тутам/ эрүүл мэндийн шинжилгээнд /цагаан хорхой, рентген, арьс, хелико/ хамруулж цагаан дэвтэр дээр бөглүүлдэг.
3	4	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 Дугаар 2015.09.01	11.2.. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Тус төв нь нийт 3 машинтай 2 жолоочтой үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жолоочид гэнэтийн ослын анхан шатны сургалтад хамрагдсан мөн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж жил бүр автотээврийн оношлогоонд оруулдаг. Жолооч нарыг нэгдсэн журмаар ажилчидтай хамт жилд 1 удаа бүрэн шинжилгээ оношлогоонд оруулдаг.
	6	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай	14.4.. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл болон хүний нөөцөд тавих	Манай байгууллага А,Б гэсэн үндсэн 2 тусламж үйлчилгээ 4 давхарт нийт 10,000 м ² талбай бөгөөд ариутгалын нэгдсэн стандартын 196 м ² ариутгалын тусдаа байртай.

		2016-04-22 Дугаар 2016.04.22	шаардлагыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага стандартын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батална.	Тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл нийт давхардсан тоогоор 636 байна.
	7		15.22.. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын жишиг хэмжээ, олгох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Тус төвийн ТУЗ нь 2020 онд ЭМСайдын тушаалаар байгуулагдсан ба гишүүдийн урамшуулал, цалин хэмжээг Сангийн сайдын, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан тушаал №А/67 тоот тушаалын дагуу олгож ажиллаж байна.
	8		21.6.. Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сонгон шалгаруулах болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Засгийн газар батална.	Тус төв нь 2022 онд ЭМДЕГ-ын сонгон шалгаруулалтад орж гэрээ байгуулан, гэрээний дагуу тусламж үйлчилгээг үзүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2020 онд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг АӨСҮТөвийн ТУЗ-өөр батлуулсан ба шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг гарган, тайланг хагас бүтэн жилээр ТУЗ-д танилцуулан, ЭМЯ-руу явуулдаг.
8	15	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	-Хүний нөөцийн алба нь Монгол улсын хууль, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журам, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан журам, Эрүүл мэндийн сайдын албан даалгаврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. - 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 362 тушаалыг боловсруулан хуулийн зөвлөхөөр хянуулж, гүйцэтгэх захирлаар батлуулсан. Үүнээс А буюу үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 54, Б тушаал буюу хүний нөөцтэй холбоотой 308 тушаал гарсан байна. -Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/26 дугаар тушаалаар төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан

			<p>боловсруулж kpi.derma.gov.mn-ээр гүйцэтгэлийг үнэлж эхэлсэн байна.</p> <p>-2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн Б/177 дугаар тушаалаар нийт албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг 10-20 хувиар нэмэгдүүлэн хөдөлмөрийн дотоод журамд клиникийн профессор, магистр, төрөлжсөн нарийн мэргэжлийн нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 5-10 хувь, арьсны идээт болон бусад халдварын эрсдэлтэй өвчтөнд сувилахуйн гардан тусламж үйлчилгээг үзүүлдэг сувилагч, туслах сувилагч нарт 10 хувийн халдварын нөхцөлийн нэмэгдлийг өгөхөөр нэмэлтээр тусган ажилласан байна. Мөн урамшуулал, олговрын хэмжээг нэмэгдүүлсэн байна.</p> <p>-2022 оны тайлант хугацаанд тус төв нь 49 эмч, эмнэлгийн ажилтанг түр болон үндсэн ажилтнаар томилсон бол 39 алба хаагчийг ажлаас чөлөөлсөн байна. Үүнээс 35 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн бол 2 алба хаагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан шалтгаанаар, 2 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг дуусаж сунгалгүйгээр ажлаас чөлөөлсөн байна.</p> <p>-АӨСҮТ-ийн захирлын 38 тушаалаар 57 эмч, эмнэлгийн ажилчдыг тасаг, албан тушаал сэлгүүлэн шилжүүлэн ажилласан байна.</p> <p>-Нийт 10 ажилтанг гэрээгээр ажиллуулан тухай бүр гэрээний хугацааг сунгаж ажиллаж байна. Үүнд: Санхүүгийн аудит, их эмч, сувилагч, цахим бүртгэгч, цахилгаанчин зэрэг албан тушаалууд багтсан байна.</p> <p>-Тус төвийн дотоод хяналтын нэгж төвийн нийт 152 эрүүл мэндийн ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийн байдалд 9 чиглэлээр хяналт шинжилгээ үнэлээг хийсэн. Дээрх үнэлгээнд 152 ажилтантай хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж баталгаажуулан, ажиллах хугацаа, ажил үүрэг, ажил амралтын цагийг тодорхойлон, цалин хөлс, хөнгөлөлт, хангамжийг тогтмол хугацаанд олгож байна.</p>
--	--	--	---

			<p>Хөдөлмөрийн аюулгүй орчныг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тусгасан ажлыг бүрэн хэрэгжүүлэн гэрээний хэрэгжилтийг улирал бүрээр дүгнэж Эхний хагас жилийн гүйцэтгэлийн урамшуулалд 144 эмч, эмнэлгийн ажилтанд 131,417,546 /нэг зуун гучин нэгэн сая дөрвөн зуун арван долоон мянга таван зуун дөчин зургаа/ төгрөг, III улирлын гүйцэтгэлийг урамшуулалд 134 эмч, эмнэлгийн ажилтанд 78,850,534 /далан найман сая найман зуун тавин мянга таван зуун гучин дөрөв/ төгрөг, 10, 11 дүгээр сарын гүйцэтгэлийн урамшуулалд 137 эмч, эмнэлгийн ажилтанд 61,768,365 /жаран нэгэн сая долоон зуун жаран найман мянга гурван зуун жаран тав/ төгрөг нийт 272,036,445 /хоёр зуун далан хоёр сая гучин зургаан мянга дөрвөн зуун дөчин тав/ төгрөгийн урамшуулал олгосон байна. Хөдөлмөрийн гэрээний дагуу хүлээх захиргааны болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагын дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллахад сургалтын алба, ёс зүйн хороо хамтарч сургалтын арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байсан.</p> <p>- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор “Өмгөөллийн лоо стратеги” ХХК-тай хийсэн хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу хамтран Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн, эмч, эмнэлгийн ажилтнуудаас санал авч, удирдлагын багаар хэлэлцүүлэн шинэчилсэн хөдөлмөрийн гэрээг эхний хагас жилийн байдлаар нийт 152 ажилтантай байгуулсан.</p> <p>- 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс Хөдөлмөрийн тухай шинэчилсэн хуулийг дагаж мөрдөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд эхлүүлэхээс өмнө 2021 онд дээрх хуулиар 2 удаагийн сургалтыг танхим болон цахимаар хэлбэрээр зохион байгуулан байгууллагын фейсбүүк хуудсанд лайв хэлбэрээр байршуулсан. 2022 онд хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор фейсбүүк хуудсан заалт бүрээр 7 хоног бүр эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэгийг дээшлүүлэн, таниулах үйл ажиллагааг явуулж байна.</p>
--	--	--	--

12	28	Засгийн газрын тусгай сангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2019-11-13 Дугаар 2020.01.01	19.5.. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.	Тус төвийн харшил судлал лабораторийн ХАРШИЛ ТӨРҮҮЛЭГЧ УРГАМЛЫН АГААР ДАХЬ ТООСЖИЛТЫН ХУАНЛИЙГ, ӨДӨР ТУТМЫН ЦАГ УУРЫН МЭДЭЭНД ОРУУЛЖ ХАРШЛААС СЭРГИЙЛБЕ” төсөл нь 2022 онд эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр үйл ажиллагаа явагдаж байгаа ба улирал бүр төслийн хэрэгжилтийн тайлан мэдээг эрүүл мэндийг дэмжих сан руу явуулдаг.
13	29	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас	7.1.1. цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалт тогтоох, зайнаас харьцах зэрэг шаардлагатай арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагын саналыг үндэслэн авах, тэдгээрт мөрдөх журам, зааврыг батлах; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./	АӨСҮТөвийн А, Б корпусийн орох гарах хэсэгт телевиз, зурагт хуудас зэрэг сурталчилгааны хэрэгслийг ашиглан коронавирусын халдвараас хэрхэн сэргийлэх, амны хаалтыг хэрхэн зөв хэрэглэх, гарын ариун цэврийг хэрхэн сахих, ахмад настан, архаг хууч өвчтэй хүмүүст анхаарах зүйл, дархлааг хэрхэн дэмжих, өрх гэрийн цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийн талаар зөвлөмж, анхааруулга, мэдээ мэдээллийг ил тод байршуулсан. Цахим бүртгэлийн хэсгийн дэлгэцээр (COVID-19)-аас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зөвлөмж, мэдээлэл сэрэмжлүүлгийг тогтмол мэдээлж байна.
	30	цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29	7.1.4.. Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	Лабораторийн их эмч Б.Сүхболд, тархвар судлаач Г.Долгорсүрэн нар коронавируст халдварын батлагдсан тохиолдол дээр ажиллах эмч, эмнэлгийн ажилчидад Хөдөлмөрийн аюулгүй байдал, халдвараас сэргийлэх арга хэмжээ, хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөж, аюулгүй тайлах, чанарын албаны дарга Б.Баярмаа сэтгэл зүйн зөвлөгөө, сувилахуйн албаны дарга Ө.Ариунаа сувилахуйн ур чадвар сэдэв дор сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт 2 багийн 12 ажилтан хамрагдсан. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэлийг ногоон бүсэд байршуулсан. Тусгаарлах өрөөнд эмчилгээнд хэрэглэгдэх нэг удаагийн багаж хэрэгслийн нөөцийн бүрдүүлэлтийг улаан өнгөтэй тэргэнцэр дотор байрлуулсан:Уян зүүний набор /наалт, боолт/-1ширхэг • Катетрын набор-1ширхэг • Пульоксиметр-1ширхэг • Нэрмэл ус-1литр • Халуун хэмжигч-1ширхэг • Чагнуур аппарат-1ширхэг

			<ul style="list-style-type: none"> • Амьсгалын аппаратын гуур-1ширхэг • 1 удаагийн тариур зүү-1 мл-1 ширхэг, 5 мл-2 ширхэг, 10 мл-2ширхэг, 20 мл-2 ширхэг тус тус бэлдсэн.
31		7.1.7.. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд болон зарим нутаг дэвсгэрийн хэмжээнд хязгаарлах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	2022 онд байгууллагын хэмжээнд нийтээр тэмдэглэх баярын өдрийг зохион байгуулаагүй.
32		7.1.11.. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ 😊)	Коронавирус халдварын мэдээ мэдээллүүдийг эмнэлгийн дотоод хуудсанд байршуулж мэдээллээр хангаж байна. Томуугийн мэдээ мэдээллийг тухай бүрт нь эмнэлгийн цахим хуудсанд байршуулж байна.
35		7.1.15.. цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой 3 сараас доошгүй хугацааны зардлыг шийдвэрлэх; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./	2022 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж бодисын жагсаалтыг багц болгон төсөвт батлуулж худалдан авах тендерийг 1-дүгээр сард зарлан зохион байгуулсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөцийг бэлдсэн.
36		7.1.16.. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм,	Хөдөлмөрийн шинэчилсэн хууль 2022-01-01 өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.2, 69 дугаар зүйлийн 69.1.2, цалин хөлс, олговор бүлгийн 101, 102, 103, 104, 105, 106, 107, 108, 109, 110, 115, 117 дугаар зүйлд заасны дагуу цалин, нэмэгдэл хөлсийг эхний хагас жилд хууль, тогтоомжийн дагуу 152 ажилтанд олгож байна. Эрүүл мэндийн


			<p>эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ 😊</p>	<p>сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн Коронавирус халдварын үед мөрдөх түр заавар, АӨСҮТ-ийн Гүйцэтгэх захирлын 2022-01-17 өдрийн Б/22 тоот тушаалаар ковидын тасагт ажиллах эмч эмнэлгийн ажилчдыг хуваарь, нэмэгдэл хөлс олгох тушаал гарсан бөгөөд дээрх тушаалаар эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дайчлагдан ажиллах эмч, эмнэлгийн ажилчдын цалин хөлсийг хэвийн бус нөхцөлөөр тооцон нэмэгдлийг 30 хувиар, тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг 20 хувиар, бусад эмч, эмнэлгийн ажилчдад ур чадварын нэмэгдлийг 20 хувиар, ажлын цагийг богиносгосон цагаар тооцон, холбогдох хууль дүрмийн дагуу олгохоор шийдвэрлэн олгосон. Коронавирус Ковид-19 цар тахлын үед батлагдсан тохиолдолд ажилласан эмнэлзүйн 2 баг, 19 эмч, эмнэлгийн ажилчдад 890 илүү цагийн хөлс болох 7.944.000 төгрөг, 920 шөнийн цагийн нэмэгдэл хөлс 920.000 төгрөгийг эхний хагас жилийн байдлаар олгосон. 2022 оны эхний хагас жилд 48 /давхардсан тоогоор/ ажилтан ковид-19 халдвараар өвчилсөн ба ЭМС-ын А/36 тоот тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу ажилчдыг анх өвдсөн бол 10 хоног, давтан өвдсөн бол 7 хоног гэрийн тусгаарлалтад оруулсан.ба тэдгээр ажилчдын үндсэн цалинг 100 хувиар тооцон олгосон.</p>
37			<p>7.1.17. цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</p>	<p>АӨСҮТ-ийн гүйцэтгэх захирлын А/456 тоот тушаалаар батлагдсан коронавируст халдварын тандалт судалгаа, коронавируст халдварын бэлэн байдлыг хангах, халдварын сэргийлэлт, хяналтын түр заавар хэрэгжүүлэх хариу арга хэмжээний багийг бүрдүүлж, батлагдсан болон сэжигтэй тохиолдол дээр ажиллах 7 хүний бүрэлдэхүүнтэй шуурхай хариу арга хэмжээний 4 багийг бүрдүүлж, Коронавирусын халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдолд эмчийн үзлэг хийж, тархвар судлалын судалгааны хуудасны дагуу мэдээлэл цуглуулан, хавьтлыг тогтоох зорилгоор эмнэлзүйн эмч, тархвар судлаач эмч, сувилагч, ариутгагч, жолооч нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Багийн гишүүдийг хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн, зөв өмсөж тайлах, эрэмбэлэн ангилал, тандалт судалгаа,</p>

			шаардлагатай мэдээллийг холбогдох хүмүүс, байгууллагад шуурхай хүргүүлэх, сорьц хадгалах тээвэрлэх
38		7.1.21.. коронавирусын халдвар авсан, халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, хуульд заасан аргаар таслан зогсоох; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./	Коронавирусын халдварын өвчтэй иргэдийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх талаар байгууллагын нийт эмч, эмнэлгийн ажилчдад ухуулан таниулж, зөвлөгөө зөвлөмжийг түгээсэн. Байгууллагын пэйж болон амбулатори, хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд халдвартай иргэдийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, талаар 3 төрлийн 250 ширхэг гарын авлага, мэдээллийг иргэдэд түгээж ажилласан.
40		7.1.23.. цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./	<p>Эмнэлгийн үйл ажиллагаанд 2022 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж бодисын жагсаалтыг 35 багц болгон 1,400,000,000 төгрөгийн төсөвт батлуулж худалдан авах тендерийг 1-дүгээр сард зарлан зохион байгуулсан. Нээлттэй тендер 2 удаа, хязгаарлагдмал тендер 1 удаа зарласан. Нийт 20 ЭХНБ-тай гэрээ байгуулан ажиллаж байна.Ерөнхий гэрээний дагуу 62 нэр төрлийн эм, 1 нэр төрлийн эмнэлгийн хэрэгслээр 36 удаа гэрээ байгуулан эм бараа татан авч тасралтгүй ханган ажилласан. Нийт арьсны өвчний үед хэрэглэх эм эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуураас гадна мөн цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор ковид-19-ын эмчилгээний тасагт хэрэглэгдэх эм, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисоор тасралтгүй ханган ажилласан байна. Ковидын эмийн нөөцийг 18 нэр төрлийн эм /150.000.000 төгрөг/, 17 нэр төрлийн эм эмнэлгийн хэрэгсэл /185.000.000төгрөг /-ээр бүрдүүлэн бэлтгэж эмчилгээ үйлчилгээнд эм эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсгэлгүй, тэгш хүртээмжтэй хангаж ажилласан.</p> <p>Амбулаторийн эмийн сангаар иргэдэд 373 нэр төрлийн эм эмнэлгийн хэрэгслээр ханган ажилласан байна.</p>
42		9.1.. Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг	Коронавируст халдварын батлагдсан тохиолдол дээр ажиллах халдвараас сэргийлэх арга хэмжээ А/36 тоот тушаал/ • ЭМС-ын 36 тоот тушаал Коронавируст (КОВИД-19) халдварын тандалт

			<p>шаардлагатай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>сэргийлэлт, хариу арга хэмжээний заавар сургалт зохион байгуулсан. АӨСҮТ-ийн гүйцэтгэх захирлын А/156 тоот тушаалаар батлагдсан коронавируст халдварын тандалт судалгаа, коронавируст халдварын бэлэн байдлыг хангах, халдварын сэргийлэлт, хяналтын түр заавар хэрэгжүүлэх хариу арга хэмжээний багийг бүрдүүлж, батлагдсан болон сэжигтэй тохиолдол дээр ажиллах 7 хүний бүрэлдэхүүнтэй шуурхай хариу арга хэмжээний 4 багийг бүрдүүлж, Коронавирусын халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдолд эмчийн үзлэг хийж, тархвар судлалын судалгааны хуудасны дагуу мэдээлэл цуглуулан, хавьтлыг тогтоох зорилгоор эмнэлзүйн эмч, тархвар судлаач эмч, сувилагч, ариутгагч, жолооч нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Багийн гишүүдийг хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн, зөв өмсөж тайлах, эрэмбэлэн ангилал, тандалт судалгаа, шаардлагатай мэдээллийг холбогдох хүмүүс, байгууллагад шуурхай хүргүүлэх, сорьц хадгалах тээвэрлэх, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн талаар сургаж бэлтгэсэн. 2022 оны 1 сараас эхлэн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг ханган ажиллаж байгаа, коронавирус халдварын сэжигтэй болон магадлалтай тохиолдол дээр антиген суурилсан түргэвчилсэн шинжилгээ хийж, эерэг гарсан тохиолдлыг өрх дүүргийн хяналт оруулж, зөвлөгөө өгч ажиллаж байна. Шуурхай арга хэмжээний баг нь сэжигтэй тохиолдолд антиген илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ хийж, голомтод халдваргүйжүүлэлт хийж ажиллаж байна.</p>
43			<p>9.3.. Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. /Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	<p>Эм эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын 2 сарын нөөц бэлдсэн. Гар халдваргүйжүүлэх уусмал: ЭМС-н А/537 дугаар тоот тушаалын дагуу гар халдваргүйжүүлэх уусмалыг дотооддоо найруулж эмнэлгийн ажилчид болон үйлчлүүлэгч нарын гарыг халдваргүйжүүлж байна. Спиртийн агууламж нь 70 хувь бөгөөд арьсыг хуурайшуулахаас сэргийлсэн зөөлрүүлэгч бодистой, эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэл, зөвшөөрөлтэй гар халдваргүйжүүлэх бодис хэрэглэж байна. Гипохлорид кальци: 30кг-2 сарын нөөцтэй байна. Жавелионы нөөц: 6 хайрцаг 1 сарын нөөцтэй байна. Давтан, хэрэглэгдэх</p>

				багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх уусмал: Sekusept Extra N халдваргүйжүүлэх бодис (10л-2 сарын нөөцтэй байна) Детерж анион нөөц: 18литр 3сарын нөөцтэй байна.
	44		9.4. Халдварт өвчнөөс хамгаалах зориулалттай эмнэлгийн хэрэгслийг эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг тодорхойлсон лабораторийн шинжилгээг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эмнэлгийн хэрэгсэл хангах нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага улсын хилээр оруулах бөгөөд хамгаалах хэрэгслийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./	Гар халдваргүйжүүлэх уусмал: ЭМС-н А/537 дугаар тоот тушаалын дагуу гар халдваргүйжүүлэх уусмалыг дотооддоо найруулж эмнэлгийн ажилчид болон үйлчлүүлэгч нарын гарыг халдваргүйжүүлж байна. Спиртийн агууламж нь 70 хувь бөгөөд арьсыг хуурайшуулахаас сэргийлсэн зөөлрүүлэгч бодистой, эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэл, зөвшөөрөлтэй гар халдваргүйжүүлэх бодис хэрэглэж байна. Гипохлорид кальци:Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийн үед ариун цэврийн өрөөнд 0.5%-ийн процентоор найруулж хэрэглэж байна. 10л уусмалд 125 гр хийж найруулна. 3. Жавелионы нөөц: Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед 10л уусмалд 4 ширхэг 0.06%-ийн процентоор өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлж байна. Incidin plus-Тусгай аппаратаар 0.5% процентоор найруулж хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ. 5. Клорсепт: 0.05% процентоор найруулж хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ. 6. Давтан, хэрэглэгдэх багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх уусмал: Sekusept Extra N халдваргүйжүүлэх бодис (5л-2мг уусмал) Aniosyme synergy 5 - цусны бохирдол задлах бодис (5л-2мг уусмал)
15	48	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Арьсны өвчин судлалын үндэсний төв нь улсын хэмжээнд арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилгын

				<p>хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүнг https://derma.gov.mn/ цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулдаг.</p> <p>Олон улсын түвшинд хүрсэн арьс-харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээг чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэх эрхэм зорилгын хүрээнд 2013 онд олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008, MNS.ISO 9001:2010 стандартыг салбартаа анхдагчаар нэвтрүүлж, 2018, 2022 онуудад амжилтаа бататган ISO9001:2015, MNS.ISO 9001:2016 стандартыг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2020-2024 онд хэрэгжүүлэх хөгжлийн стратеги төлөвлөгөө нь 8 үндсэн чиглэлийн хүрээнд шинэ дэвшилтэд технологийг нэвтрүүлэн, арьс-харшил, эмчилгээний гоо заслын оношилгоо, эмчилгээг чанарын өндөр түвшинд хүргэхийг зорьж ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Байгууллагын эрхэм зорилго - олон улсын түвшинд хүрсэн арьс-харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээг чанартай шуурхай үзүүлэх ❖ Эрхэмлэх үнэт зүйлс: <ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж - Бидний итгэл, найдвар - Үйлчлүүлэгчийн арьсны эрүүл мэнд - Бидний чанарын баталгаа - Үйлчлүүлэгчийн эдгэрэлт – Бидний дэвшил, хөгжил - Үйлчлүүлэгчийн инээмсэглэл - Бидний ёс зүй, хариуцлага
49			8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 сарын 17-ны өдрийн 06/20 дугаар “Эмнэлгийн бүтэц, орон тоог батлах тухай” тогтоолоор батлагдсан төвийн бүтэц орон тооны схемийг https://derma.gov.mn/ -д цахим хуудсандаа байршуулсан.

				 <p>Chatbot ХХК автомат хариулагч угсралтын байгууллагатай хамтарч ажиллаж байна. Уг автомат хариулагч нь иргэдэд тусламж үйлчилгээний талаар түгээмэл асуудаг хэрэгтэй мэдээллийг оруулсан. Одоогоор нийт 28398 иргэдийн асуултанд хариу өгсөн байна. Түүнчлэн Иргэд, үйлчлүүлэгчдэд зориулан лавлагаа, үйлчилгээний 70135036 утсыг тогтмол ажлуулж, нийслэлийн болон орон нутгийн иргэдэд үзлэгийн цаг олгож байна. 2022 онд нийт 54837 гаруй үйлчлүүлэгч утсаар цаг захиалсан байна.</p> <p>Байгууллагын цахим хуудсанд байгууллагын хаяг, байршил, харилцах, утасны дугаар, шуудангийн хаяг зэргийг ил тод, нээлттэй байршуулсан. Үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах хэсгийг шинээр ажиллуулж эхэлсэн ба талархал 1, санал хүсэлт 2, асуулт, зөвлөгөө 3 ирснийг холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлж шийдвэрлүүлсэн.</p>
50		8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Санхүүгийн аудитаар бүртгэл, авлага барагдуулах, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулах, нийгмийн даатгалын шимтгэл, татварын тайлагнах зэрэг нийт 6 зөрчил илрүүлж албан шаардлага өгснийг арилгаж хэрэгжүүлж ажиллаж байна.	
51		8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Эрүүл мэндийн яам руу хагас бүтэн жилээр гарган хүргүүлж хяналт үнэлгээ хийлгэж байна.	Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу арьс, харшлын төрөлжсөн нарийн

				<p>мэргэжлийн тусламж үйлчилгээг бүрэн хэрэгжүүлж, зардлыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасны дагуу тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу эмч, эмнэлгийн ажилчдын хооронд хөдөлмөрийн харилцааг оновчтой үр ашигтай зохион байгуулж, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэх, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн сахилга батыг бэхжүүлэх зэрэг харилцааг хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>Статистикийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвд сар бүр хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн мэдээг 20 үзүүлэлтээр мөн халдварт өвчний өвчлөл, нас баралтын мэдээг 4 үзүүлэлтээр тус бүр гарган тайлагнадаг. Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу бүх арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу зардлыг бууруулан төсвийг үр ашигтай зарцуулж байна. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх өдрийн хүрээнд манай байгууллага идэвхтэй оролцсон. Шилэн дансны хуулийн хээгжилтийг хангаж сар бүр санхүүгийн мэдээ тайланг шилэн дансанд байршуулдаг. Эрүүл ахуйн хуулийн хүрээнд МС-ын а/505 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг энгийн болон аюултай хог хаягдлаар ангилан ялгалт хийж, тэмдэг тэмдэглэгээг байршуулж зөв ангилан ялгаж байна.</p>
	52		8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж 2022 оны байгууллагын хөгжлийн бодлого төлөвлөлтийг 6 зорилтын хүрээнд нийт 50 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 97 хувьтай бна. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн батлагааг

			хангах хөтөлбөрийн биелэлт, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлийн хэрэгжилтийн тайланг ЭМС-ын 07 сарын А/340 тоот тушаалын дагуу хугацаанд нь ЭМЯ-руу хүргүүлсэн.
53		8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Засгийн газрын тогтоолууд, 2 сайдын хамтарсан тушаалууд, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавруудыг үйл ажиллагаандаа дагаж мөрддөг. Байгууллагын цахим хуудасны “Хууль эрх зүй” цэсэнд Монгол Улсын Хууль 13, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол 4, Эрүүл мэндийн сайдын тушаал 32, байгууллагын Гүйцэтгэх захирлын тушаал 31-ыг тус тус иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй харагдахаар байршуулсан.
54		8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Захиргааны ажилчдын овог нэр, албан тушаал, харилцах утасны дугаар, майл хаяг, өрөөний дугаарыг иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод байршуулсан. Мөн хүний нөөцийн менежерийн баталсан “Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал, иргэдийг хүлээн авах цагийн хуваар”-ийг байгууллагын цахим хуудас болон ил тод байдлын мэдээллийн самбарт тухай бүрд шинэчлэн байршуулдаг.
55		8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Иргэний өргөдөл, гомдлыг аман, биечлэн, утсаар, цахим хуудсаар, 11-11, бичгээр, санал хүсэлтийн дэвтэрээр хүлээн авч бүртгэн, хариу арга хэмжээ авч шийдвэрлэн ажилладаг. Улирал бүр иргэний өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлдэг. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 50 буюу санал 18, хүсэлт 9, өргөдөл, гомдол 23 хүлээн авч 100% шийдвэрлэн ажилласан. Мөн 8 талархал ирсэн байна.

56		8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	<ol style="list-style-type: none"> 1. Амбулаторийн үзлэг нийт -82,845 2. Хэвтэн эмчлүүлсэн нийт-3866 3. Өдрийн эмийн эмчилгээ -480 4. Эрчимт эмчилгээ нийт – 179 5. Зөвлөх эмч, эмч нарын хамтарсан үзлэгт нийт-153 6. Онош тодруулахаар -78 7. Эмчилгээний заалт авахаар -124 8. Ор хоног сунгахаар -19 9. Комиссын шийдвэр авахаар -1 10. Эрчимт эмчилгээнд шилжүүлэх эсэхийг шийдэхээр -1 11. Онош батлахаар -1 12. Эмнэлгээс гаргах эсэхийг шийдэхээр -1 13. Цаашдын эмчилгээний заалт авахаар -7 14. Яаралтай тусламж нийт -4094 15. Оношилгоо шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгч - 58,989 16. Сэргээн засах эмчилгээнд хамрагдсан -2741 17. ЭМД-аар өдрийн мэс засал хийлгэсэн хүний тоо -7 18. ЭМД-аар амбулаториор мэс ажилбар хийлгэсэн -36 19. Орны фонт ашиглалтын хувь -78,8% 20. Дундаж ор хоног -8 <p>Нийт ор хоног -33,380</p>
57		8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	<p>2022 онд дараах чиглэлээр аян болон бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулагсан:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд аяны уриалгатай байгууллагын логотой ковер, профайл зургийг нийт 130 эмч, эмнэлгийн ажилчид шинэчилж аянд нэгдсэн. 2. “Хамтдаа ярилцъя” өглөөний цай арга хэмжээ: Ажилчдын хоолны зааланд 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан бөгөөд эрчүүдээ хүндэтгэе, эрүүл өглөөний цайг хамтдаа сэдвээр нэг өглөөг эрч хүчээр дүүрэн эхлүүлсэн. Тус үйл

				<p>ажиллагааг эмч, эмнэлгийн ажилчид дэмжин уламжлалт болгон зохион байгуулахаар болсон.</p> <p>3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах сарын хүрээнд: 2022 оны 08 дугаар сард Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сарын аяныг зохион байгуулж нийт эмч, эмнэлгийн ажилчдын үндсэн цалинг 10-20 хувиар нэмэгдүүлсэн. Мөн байгууллагын ажилчдыг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлснээр нийт 9 ажилтанд орон сууц болон хашаа байшингийн урьдчилгаа төлбөр, ипотекийн зээлийн хөнгөлөлт, монгол үндэсний гэр олгож ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>4. “Ахмад настныг дэмжих сарын аян”-ы хүрээнд Геронтологийн Үндэсний төвтэй хамтран 2022 оны 10-р сарын 28-ны өдөр “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулж байгууллагын ахмадуудад урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээ, эрүүл мэндийн зөвлөгөө өгч ажилласан. Үүнд: Арьс харшлын эмчийн үзлэг 18, зүрхний эмчийн үзлэг болон зүрхний цахилгаан бичлэг 17, хэвлийн хэт авиан шинжилгээ 19, сэргээн засах эмчийн үзлэг 16, ясны сийрэгжилт тодорхойлох шинжилгээнд 15 ахмад тус тус хамрагдаж, давхардсан тоогоор 84 ахмад настан үзлэг, шинжилгээнд хамрагдсан.</p> <p>5. “Хөдөлгөөн эрүүл мэнд” арга хэмжээний хүрээнд 2002 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Эрүүл мэндийн сайдын санаачилгаар зохион байгуулагдсан “Алхангаа ярилцъя” аянд байгууллагын 30 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцсон. Үйл ажиллагааны үеэр нийт 200 ширхэг гарын авлага түгээж, 150 хүнд газар дээр нь арьсны өвчний талаарх зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Мөн Эрүүл мэндийн сайдын санаачилгаар зохион байгуулагдсан “Дугуйн аялал” 2022-д амжилттай оролцсон.</p>
--	--	--	--	--

			6. “Үйлдвэрчний эвлэлийн хороо”-ны нэрэмжит гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, шатар, ширээний теннисний 5 төрөлт спортын арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан.
58		8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn болон https://zangia.mn сайтад сул орон тооны сонгон шалгаруулалтын зарыг тогтмол байршуулдаг. Байгууллагын цахим хуудсанд нийт 47 нээлттэй ажлын байрны зар байршсаны 6 нь 2022 онд шинээр зарлагдсан байна. Мөн https://zangia.mn сайтад нийт 75 анкет ирүүлсэнг хүлээн авч сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй хийсэн.
59		8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 09-р тогтоолоор батлагдсан “Гүйцэтгэх захирал болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулах журам”-ын дагуу 4 нэгжийн менежерийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Мөн “Шинэ ажилтныг сонгон шалгаруулж, ажиллуулах журам”-ыг боловсруулан батлуулж сонгон шалгаруулалтыг тухай бүр ажлын хэсэг байгуулан /тест, ярилцлага/ гэсэн 2 үе шаттайгаар холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулж байна.
60		8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	2022 оны 06 сарын 10, 11-ны өдрүүдэд “Эрүүл мэндийн чанарын холбоо ТББ”-тай хамтран “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал” сэдэвт чанарын сургалт зохион байгуулсан. Тус сургалтад тасаг нэгж, албадын чанарын багийн ахлагч 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. 2022 оны 03 сарын 04-ны өдөр "Сэтгэцийн эрүүл мэнд болон стресс тайлах" сэдэвт сургалтыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэл зүйч Б.Ариунцацралтай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад нийт 32 ажилтан оролцсон. 2022 оны 06-р сарын 10-ны өдөр “Эрүүл мэндийн чанарын холбоо”-ны гишүүн Ш.Нармандах “Байгууллагын соёл” сургалтыг тасаг нэгж, албадын чанарын багийн нийт 35 ажилтнуудад орсон. Сургалтад хамрагдсан ажилчид бусад ажилчдаа сургалтыг 3-р улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

				<p>Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг сайжруулах зорилгоор 2022 оны 06 сарын 15-нд ХТС-ийн захирал, НЭМГ-ын Ёс зүйн хорооны дарга, зөвлөгч багш Б.Одгэрэл-ыг урьж "Байгууллагын шинэ соёл" сэдвээр сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 44 ажилтан, 13 резидент эмч нар хамрагдсан.</p> <p>Ёс зүйн салбар хорооны самбарыг поликлиникийн тасгийн цахим бүртгэлийн хэсэгт байршуулан үйлчлүүлэгчдэд ёс зүйн холбогдол бүхий мэдээ мэдээлэл, үйл ажиллагааны талаар нийт 5 удаагийн мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулсан.</p> <p>Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захиралын 2022 оны 12 дугаар 01-ний А/47 тушаалаар “Ёс зүйн салбар хороо”-г шинэчлэн байгуулж:</p> <ul style="list-style-type: none"> - 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр ЭМС-ын А/319 дүгээр тушаалаар “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сургалт - 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Кредиттэй “Ёс зүйн сургалт” цахимаар - 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ЭМС-ын А/406 дугаар тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” сургалт - 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хүний эрхийн үндэсний комиссын “Хүний эрхийн мэдрэмж, ажлын байрны дарамт, ажлын байрны үүрэг хариуцлага ялгаа” сургалтуудыг зохион байгуулж кредиттэй сургалтад 58 ажилтан, бусад сургалтад давхардсан тоогоор 100 гаруй ажилтан, албан хаагчийг хамруулсан.
61			8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	2022 оны I улиралд 2022-2026 оны байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, тасралтгүй суралцагч байгууллага байж, хүний нөөцийг хөгжүүлэх, сургалт хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд 5 үйл ажиллагаа төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шаттайгаар хангаж ажиллахын

				<p>тулд 2022 оны байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусган, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны MNS6330:2017 стандартаар эмч, сувилагчийн харьцаа 1:1.5 хүргэхээр төлөвлөн ажиллаж байна. 2022 онд поликлиникийн тасагт 1, ЭЭЯТ-т гэрээт 1, хүүхэд асрах чөлөөнөөс 1 нийт 2 сувилагч, 1-р тасагт 1, Хүүхдийн тасагт 1 гэрээт сувилагч нийт 5 сувилагчийг сонгон шалгаруулж шинээр ажилд авсан. 2. Дотоодын 13 төрлийн сургалтад давхардсан тоогоор нийт 300, гадаад улсад 24 эмч, ажилчид давхардсан тоогоор нийт 250, бусад байгууллага, нийгэмлэгээс зохион байгуулсан 29 сургалтад хамрагдаж, өндөр хөгжилтэй гадаадын орнуудад нийт 4 эмч амжилттай суралцаж төгссөн. 3. 2022 онд 8 эмч, эмнэлгийн ажилтан зэрэг хамгаалсан. 4. Нийт 16 эмч, эмнэлгийн ажилчид эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцсон. <p>Байгууллагын зардлаар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Баярмаа эрүүл мэндийн удирдлагын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж сургалтын зардал 736,000 төгрөг 2. Архив, номын санч Т.Мөнхцацрал архивын сургалтад хамрагдаж сургалтын зардал 80,000 төгрөг 3. Эмчилгээний гоо сайхан нөхөн сэргээх тасгийн туслах сувилагч Н.Мөнхтогоо гоо заслын сургалтад хамрагдаж сургалтын зардал 399,000 төгрөг 4. Программ хангамжийн инженер Б.Дөл систем хөгжүүлэлтийн сургалтад хамрагдаж 385,000 төгрөг 5. Төрийн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ олгох сургалтад программ хангамжийн инженер Б.Дөл, Эдийн засагч Б.Амарзаяа, Лабораторийн их эмч Б.Сүхболд, Аж
--	--	--	--	---

			<p>ахуйн тасгийн дарга Т.Мөнхцацрал нар хамрагдаж сургалтын зардал 320,000 төгрөг буюу нийт 2,200,000 төгрөгөөр сургалтад хамруулсан байна.</p> <p>Эмч, эмнэлгийн нийт ажилчдад чиглэсэн:</p> <ul style="list-style-type: none"> - “Менежментийн тогтолцоонд аудит явуулах” сэдэвт сургалт 180,000 төгрөг <p>“Амилуулах суурь тусламж” сэдэвт сургалт 1,320,000 төгрөг тус тус амжилттай зохион байгуулан эмч, эмнэлгийн ажилчдыг хамруулсан байна.</p>
62		8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	<p>Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж “Удирдлагын зөвлөлийн хурал”-аар батлуулж 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа тусгаж ажиллаж эхэлсэн.</p> <p>2023 оноос шинэ эмчилгээ үйлчилгээ, техник технологи нэвтрүүлэхтэй холбогдон “Байгууллагын бүтэц орон тоо, дүрэм албан тушаалын жагсаалт батлах” ажлын хэсгийг байгуулж хариуцлагатай ажилтны хурлаар танилцуулан ТУЗ /төлөөлөн удирдах зөвлөл/-өөр батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>2022 онд “Хүний нөөцийн бодлого”-ын хүрээнд Удирдах ажилтнуудыг чадавхжуулах, манлайллыг хөгжүүлэх, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар болон хувь хүнийг хөгжихөд дэмжлэг үзүүлэх, тасралтгүй сурч хөгжих хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, түлхүүр ажилтнуудын залгамж халааг бэлтгэх, байгууллагын дотоод соёл, эерэг хандлагыг бий болгох зорилгоор Дэвшилтэт технологи, шинэ санаа нэвтрүүлэн, үр ашигтай ажилласан эмч, эмнэлгийн ажилтнуудыг урамшуулан ажиллаж байна.</p>
63		8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	<p>Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/26 дугаар тушаалаар “Эмч, эмнэлгийн мэргэжилтний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулж батлуулсан.</p>

			<p>АӨСҮТ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 сарын 06-ны өдрийн 22/06 тогтоолоор “Улирлын ажлын гүйцэтгэлийн мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баталсан. Тус журмаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу эмч, ажилчдын 3 болон 4 улирлын ажлын гүйцэтгэлийг https://kpi.derma.gov.mn програм хангамж ашиглан цахимаар үнэлж урамшууллыг 90 хувиар тооцож олгосон</p>
64		8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	<p>Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, 2022 оны жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг Эрүүл мэндийн яамнаас батлагдсан төсвийг АӨСҮТ-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр хуулийн хугацаанд нь батлуулан ил тод нээлттэй байдлаар шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ болон ил тод байдлын самбарт байршуулсан.</p>
65		8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	<p>2022 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь үнэн зөвөөр зөрчилгүй Эрүүл мэндийн яаманд тайлагнасан ба шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ ил тод, нээлттэй байршуулсан.</p>
66		8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	<p>Байгууллагын 2021 оны санхүүгийн баримтыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд Үндэсний аудитын газрын 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 07/315 тоот албан бичгээр зөрчилгүй гэж дүгнэгдсэн.</p>
67		8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	<p>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49,50,51 дугаар тогтоолын дагуу “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-г Кофе шоп-ын зориулалтаар 29м.кв талбайг Батбайгаль ХХК, бэлэн мөнгөний машин буюу АТМ зориулалтаар 2 м.кв талбайг Голомт ХХК, Эмийн сангийн зориулалтаар 25м.кв талбайг Сузур фарм ХХК-тай тус тус байгуулан түрээсийн орлогын 40% болох 3 дугаар</p>

			улирлын байдлаар нийт 14,224,000.00 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.
68		8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	2022 онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамжийн бараа материал нь улирлын шинж чанартайгаар хэмнэлт, норматив зардал эм боох материалын өмнөх оны өглөгийн төлөлт хийгдээд хэтрэлт үүссэнг шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас болох https://derma.gov.mn/ -д ил тод, нээлттэй байршуулсан. Хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангаж, үр ашгийг нэмэгдүүлж ажилласан. Цалин хөлс, нэмэгдэл урамшил төлөвлөгөөнөөс 187,458,249 төгрөг буюу -7%, нийгмийн даатгалын шимтгэл 37,515,666 төгрөг буюу -10%, байр ашиглалттай холбоотой зардал 32,815,522 төгрөг буюу -21%, нормын хувцас, зөөлөн эдлэл 7,057,500 төгрөг буюу -47%, багаж, техник хэрэгсэл 105,621,920 төгрөг буюу -70%, тавилга 15,144,400 төгрөг буюу -61%, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 8,000,000 төгрөг буюу -100%, урсгал засвар 148,326,080 төгрөг буюу -31%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 30,927,774 төгрөг буюу -33%-н хэмнэлттэй ажилласан байна.
69		8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	2022 оны 12 дугаар сарын байдлаар Таван сая ба түүнээс дээш үнийн дүнтэй нийт 1,102,266,768.80 төгрөгийн үнийн дүн бүхий давхардсан тоогоор 351 бараа, ажил үйлчилгээ худалдан авсан. Үүнд: -Манхан-Өгөөж ХХК-аас 156,553,460.00 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн. -Элемент ХХК-аас 10,400,000.00 төгрөгийн Эмнэлгийн хог хаягдал тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох үйлчилгээ -32 ханган нийлүүлэгч компаниудаас нийт 935,313,308.80 төгрөгийн Эм, эмнэлгийн хэрэгсэлийг худалдан авалтыг хийсэн байна.

70		8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт цалингийн зардлаас бусад таван сая түүнээс дээш төгрөгийн нийт 171 ширхэг орлого зарлагын гүйлгээ хийгдсэн. Үүнд: -Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын сан, Эрүүл мэндийн хөгжлийн төв, байгууллагын үйл ажиллагааны орлого зэргээс бүрдсэн 55 удаагийн нийт 3,924,577,868.80 төгрөгний орлого. -Байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор Эм эмнэлгийн хэрэгсэлийн 85 зарлагын гүйлгээ /Монгол эм импекс концерн, Монбио фарм, Монфа трейд, Грийн гэйт, Дулаанхайрхан, Азифарм, Тавин ус,Монос трейд, Еврофарм, Пролианс, Ньюрфмеди, ЭНТО, Энхий шүүдэр,Сүвэн уул, Мөнхийн тун, Нахиа импекс...гэх мэт/, Хүнсний материалын 11 гүйлгээ Манхан өгөөж ХХК , бусад урсгал зардалын 85 гүйлгээ тус тус гарч нийт 1,613,694,218,28 төгрөгийн зарлага гарсан байна.
71		8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр байхгүй болно.
72		8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	2021 оны шилэн дансны хөтлөлт хэрэгжилтэд аудит шалгалт хийхэд 4,731,898.6 төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 238.9 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй шалгагдсан бөгөөд 2022 оны 11-р сарын байдлаар 155 ширхэг мэдээллийг үнэн бодитоор нь хуулийн хугацаанд нь хугацаа хоцролгүй шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ ил тод, нээлттэй байршуулан ажиллаж байна.
73		8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллага боловсруулж Гүйцэтгэх захирлаар батлуулан батлагдсан

		баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	<p>төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд нийт эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж техник хэрэгсэл, хоол хүнсний материал худалдан авах 7 удаагийн тендерт Үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо нь босго үнийн дагуу жишиг баримт бичгийг баримтлан тендерийн баримт бичгийг боловсруулан батлуулж худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж үнийн саналын нээлтийг хийж үнэлгээг хийн захиалагчид зөвлөмж хүргүүлэн ажилласан.</p> <p>Тендерийн урилгыг http://tender.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/, өдөр тутмын “Өдрийн мэдээ” сонинд нийтлэж тендерт оролцогч нарт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг албан бичгээр болон төрийн худалдан авалтын http://tender.gov.mn/ сайтад үнэлгээний хорооны нарийн бичиг тухай бүрт нь нийтлэн ажиллаж байна</p>
74		8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	2022 онд худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалт байхгүй болно.
75		8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Тендерийн үнэлгээний хорооны 7 гишүүн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох АЗ гэрчилгээний сургалтанд бүрэн хамрагдан мэргэжил, арга зүйн, зөвлөгөө, зааварчилгаагаар бүрэн хангагдсан. 2022 оны 12 дугаар сард 4 хүн АЗ гэрчилгээний сургалтанд хамрагдсан.
76		8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	2022 оны санхүүгийн жилд төсвийн хөрөнгө болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно.

77		8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил байхгүй.
78		8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Хууль тогтоомжид заагдсан бусад мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөвөөр байдлаар шилэн дансны http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ ил тод, нээлттэй байршуулан ажиллаж байна.
79		8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 сарын 25-ны өдрийн А/30 тоот тушаалаар “Төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, үнэ, тариф”-ийг баталсан ба байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ байршуулсан. Мөн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ, яаралтай тусламж, үйлчилгээ, телемедицин, өдрийн эмчилгээ, үйлчилгээ, өдрийн мэс засал, сэргээн засах тусламж, үйлчилгээнүүдийг ЭМДҮЗ-ийн 2022 оны 1 сарын 28-ны "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 01-р тогтоол, ЭМДЕГДаргын 2022 оны 4 сарын 5-ны "Жагсаалт батлах тухай" А/53 тоот тушаал, Сангийн сайд Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 2 сарын 28-ны өдрийн "Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай" 49/А118 тоот тушаалуудын дагуу ЭМД-аар үзүүлж байна.
80		8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	АӨСҮТ нь 2022 оны 03 сарын 30-нд тусгай мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Эрүүл мэндийн яам 5 жилийн хугацаатай сунгуулсан. Мөн 2021 оны 01 сарын 13-нд Хэнтий аймгаас рашаан сувиллын үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай сунгуулсан.

81		8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	<p>Байгууллын хөдөлмөрийн дотоод журмыг Үйлдвэрчний эвлэлийн хорооны болон төвийн нийт ажилчдын саналыг тусгаж 2022 оны 12 дугаар сарын 1-ны өдөр баталж мөрдөж ажиллаж байна. Хөдөлмөрийн дотоод журмаар тус төвд бүх төрлийн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд, бусад ажилтны хөдөлмөрлөх үйл ажиллагаа хамрагдан зохицуулагдаж байна.</p> <p>Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах харилцаа:</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, бүтцийн схем - Байгууллагын дотоод үйл ажиллагаа - Байгууллагын төлөвлөгөө тайлан, түүнд тавих хяналтын тогтолцоо - Хэтийн зорилго, эрхэм зорилго, зорилт, эрхэмлэх үнэт зүйл - Дотоод ажлын зохион байгуулалт - Дотоодын хяналт шалгалт - Өмч хөрөнгө хадгалалт, хамгаалалт, ашиглалт - Байгууллагын нууцыг тогтоох, хамгаалах - Ажил амралтын цагийн горим - Цалин хөлс, хөнгөлөлт, хангамж, урамшуулал - Чөлөө, томилолт - Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа - Хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлага <p>Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, цуцлах</p>
82		8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	<p>Дараах оюуны өмчийн эрхийг эзэмшиж байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол улсын зохиогчийн эрхийн гэрчилгээ №2007/173-Вудын лампыг арьс судлалын практикт хэрэглэх нь 2. Нүүрс хүчлийн хийн лазер эмчилгээ №2010 3. Монгол улсын шинэ бүтээлийн патент-Биобэлдмэлийн шинжлэх ухаан, үйлдвэр худалдааны монсерум ххк-д

				<p>4. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ- бүртгэлийн дугаар: L20191023Bi01554</p> <p>Оношлуурын нэр: хуурамч таван дохиурт бургасын харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>5. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ - бүртгэлийн дугаар: L20191023Bi01555</p> <p>Оношлуурын нэр: Хавтаг навчит хусны харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>6. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ - бүртгэлийн дугаар: L20191023Bi01553, Оношлуурын нэр: Соргүй согооврын харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>7. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01556</p> <p>Оношлуурын нэр: Лавар навчит улиасын харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>8. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01551, Оношлуурын нэр: Нугын биелэгийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>9. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01552, Оношлуурын нэр: Саман ерхөгийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>10. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01547. Оношлуурын нэр: Сиверсийн шарилжийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>11. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01548. Оношлуурын нэр: ээрэм шарилжийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p>
--	--	--	--	--

			<p>12. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01549. Оношлуурын нэр: цагаан луулийн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>13. Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01550. Оношлуурын нэр: ахар сорт арвайн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p> <p>Оношлуурын бүртгэлийн гэрчилгээ-бүртгэлийн дугаар: L20191023Bi01550. Оношлуурын нэр: ахар сорт арвайн харшил оношлох өвөрмөц уусмал аллерген сорил</p>
84		8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төв нь Нийслэлийн засаг даргын захирамжаар 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/824 тоот шийдвэрээр нэгж талбарын 1461601580 дугаар, гэрчилгээний дугаар 0000106010, гэрээний дугаар 01119-2021/04226, бүхий 6606м.кв газрыг Төрийн захиргааны байгууллага зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшиж, эрхийн бүртгэлийн Э-2203015331 дугаартай гэрчилгээг авсан
85		8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ байхгүй болно.
86		8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон	АӨСҮТ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны мэдээллийг өөрчлөх бүрд шинэчлэн байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ байршуулдаг. ЭМСайдын 2020 оны 01 сарын А/52 тоот тушаалаар АӨСҮТ-ийн ТҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг батламжилсан. Гишүүнд нэр дэвшигчид нь Өмчлөгч /Сангийн яам, ЭМДЕГ, ЭМЯ/ -ийг төлөөлсөн 3 гишүүн, Хамт олон /Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн/-г төлөөлсөн 3 гишүүн, Олон нийт /ТББ, Нийгэмлэг, ҮЭ/-г төлөөлсөн нийт 9 гишүүний

		шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	<p>бүрэлдэхүүнтэй томилсон. 2020 оны 2 сард гишүүд дундаас ТУЗ-ийн даргыг сонгосон ба нарийн бичгийн даргыг тогтоолоор баталсан. ТУЗ-ийн 2020 оны 06 сарын 17-ны өдрийн 08/20 тоот тогтоолоор эмнэлгийн гүйцэтгэх захирлаар Ц.Уранчимэгийг 5 жилийн хугацаатайгаар томилсон.</p> <p>Гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг оруулсан ба ТУЗ-ийн 2020 оны 07 сарын 08-ний 09 дүгээр тогтоолоор төвийн гүйцэтгэх удирдлага болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулах журмыг баталсан. Мөн 2022 оны төсвийг батлагдсан тогтоолыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан</p>
87		8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	<p>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн дугаар 49,50,51 тогтоолын дагуу Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг Кофе шопын зориулалтаар 29м.кв талбайг Батбайгаль ХХК, бэлэн мөнгөний машин буюу АТМ зориулалтаар 2м.кв талбайг Голомт ХХК, Эмийн сангийн зориулалтаар 25м.кв талбайг Сузур фарм ХХК-тай тус тус байгуулан түрээсийн орлогын 40% болох 3 дугаар улирлын байдлаар нийт 14,224,000.00 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.</p>
88		8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	<p>5978866 тоот регистр, АҮХ-20/22/3804 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал халдваргүйтгэлийн “Ууган хангай” ХХК-тай хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу 2022 оны 10 сарын 25-нд гэрээ байгуулж, АӨСҮТ-ийн 4032мкв талбайд өрөөний агаар, объектын хана, шал, хаалга, хаалганы бариул гэсэн гадаргуугийн бүх хэсэгт, мөн ширээ сандал, тавиур зэрэг өрөөн доторх эд зүйлст болон угаалгын өрөө, 00-ын өрөө, жорлон, гаднах орчин тус бүрд 5 процентын уусмалаар, мэрэгч устгалын үйлчилгээнд бромадиолоны өгөөш 1мкв 3-5гр нийт 4032 мкв талбайд нийт 4 удаа буюу улирал тутамд устгал хийсэн байна.</p>

			<p>Мөн “Элемент”ХХК-тай “Эм, эмийн гаралтай химийн бүтээгдэхүүн болон эмнэлгийн туслах материал тээвэрлэх, устгах гэрээ байгуулсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> - XXX-ын нийт хэмжээ 3318кг190гр, - Эмнэлгийн халдвартай хог хаягдал нийт-2395кг112гр - Хурц үзүүртэй хог хаягдал нийт- 923кг628гр <p>ба үүнийг гэрээний дагуу “Элемент”ХХК-аар тээвэрлүүлэн устгал хийлгэсэн</p>
89		8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	2022 оны 12 дугаар сарын байдлаар барилга байгууламж ашиглалтад оруулахыг хүссэн хүсэлт байхгүй.
90		8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	<p>Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй болгох зорилгоор байгууллагаас гарч буй тушаал, шийдвэр, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Тухайн онд байгууллагын цахим хуудсанд нийт 383 мэдээ мэдээллийг байршуулсан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэд, үйлчлүүлэгчдэд зориулан https://derma.gov.mn/ цахим хуудсанд:</p> <ul style="list-style-type: none"> ○ Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 29 ○ Хүний нөөцийн ил тод, нээлттэй байдал - 47 ○ Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх - 18 ○ Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн - 6 ○ Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 114 <p>тус тус байршуулсан. Мөн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/30 тоот “Төлбөртэй тусламж үйлчилгээний нэр төрөл, жишиг хэмжээг батлах тухай” тушаал батлагдсаныг байгууллагын цахим хуудас болон цахим бүртгэлийн хэсэг, кассын дэргэд ил тодоор байрлуулсан.</p>

				<p>Сошиал медиа чиглэлээр: Тухайн жилд нийгмийн эрүүл мэндийн асуудал болон зөвлөмж, тэмдэглэлт өдөр, хоол хүнс, аюулгүй байдал, дасгал хөдөлгөөн, архи тамхины хор нөлөө, арьсны өвчний талаар мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг Фэйсбүүк хуудсандаа байршуулсан. Байгууллагын пайжид нийт 3951 пост оруулсанг 30059 хүн үзэж, 149 шайр авч, 357 лайк цуглуулсан байна.</p>
	91		<p>8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;</p>	<p>Байгууллагаас санхүүжүүлсэн сургалтууд:</p> <ul style="list-style-type: none"> - 2022.1.18-ны өдөр Сургалтын албанаас “Оношийн хэлбэржилт, нас баралт, түүнийг бүртгэх, мэдээлэх нь” сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтын зардал: 450,000 төгрөг - 2022.02.18-ны өдөр Сургалтын албанаас “Байгууллагын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтын зардал: 1.500.000 төгрөг - 2022.06.15-нд Хүний их эмч, эрх зүйч Б.Одгэрэл “Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлье” чанар сайжруулах аяны хүрээнд “Байгууллагын шинэ соёл” сэдэвт сургалтыг I тасгийн зохион байгууллаа. Сургалтын зардал 100.000 төгрөг - Эрүүл мэндийн удирдлага сургалт. Сургалтын зардал 736.000 төгрөг - Архивын ерөнхий газрын сургалт. Сургалтын зардал 80.000 төгрөг - Арьсны чиглэлээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлдэг сувилагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, дадлыг нэмэгдүүлэх онол практикийн бага хурал. Сургалтын зардал: 165.000 төгрөг - 2022.09.10-ны өдөр Сургалтын албанаас Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран амилуулах тусламжийн 1кр сургалт зохион байгуулсан. Сургалтын зардал: 1.320.000 төгрөг - 2022.09.08-09-ний өдрүүдэд стандарт хэмжилзүйн газраас зохион байгуулсан “MNS ISO 9001:2016 “Чанарын удирдлагын тогтолцоо-шаардлага” сэдэвт сургалтанд

				<p>ЭМТҮЧАБА-ны дарга Б.Баярмаа, Сургалтын албаны дарга Б.Лхагвасүрэн нар хамрагдлаа. Сургалтын зардал 360.000 төгрөг.</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн чанарын холбооноос "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал" сургалт. Сургалтын зардал 600.000 төгрөг - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжруулах аян. Зардал 100.000 төгрөг. - Харшлын мэргэжил дээшлүүлэх сургалт. Сургалтын зардал 3.200.000 төгрөг - Эмчилгээний гоо заслын сургалт. Сургалтын зардал 400.000 төгрөг - Монголын сувилагчдын нийгэмлэгээс "Удирдлагын манлайлал сургалт. Сургалтын зардал 100.000 төгрөг - Эмпаттс ХХК-аас Microsoft active directory системийн сургалт. . Сургалтын зардал 385.000 төгрөг <p>Төрийн худалдан авах ажиллагааны сургалт. Сургалтын зардал 320.000 төгрөг /4 ажилтан/</p>
	92		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	2022 оны 5 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд иргэдэд мэдээллийг ил тод нээлттэй хүргэж ажиллаж байна.
УИХ-ын тогтоол				
18	99	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай	1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах;	Байгууллагын 2022-2025 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2022-06-23 өдөр байгууллагын пэйж, вэб хуудас болон фейсбүүк группт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн заалтуудыг байршуулан, гарын авлага, танилцуулах хуудас тараан байршуулсан. III-р улиралд дээрх хуулийн тухай сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сургалтын албатай хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна. Эмч, эмнэлгийн ажилчдад олон нийтийн сүлжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний

		2019-06-06 Дугаар 2019 №62		тухай мэдээ мэдээллийг өөрийн фейсбүүк хуудсанд хуваалцан мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлсэн болно.
107	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай 2020-12-03 Дугаар 2020 №36	2.7/. Иргэд, олон нийтэд хувийн ариун цэврийг сахиж, хариуцлагатай байх, бусдын эрхийг хүндэтгэх талаарх мэдээлэл, сурталчилгааг идэвхжүүлэх;		2022 оны 5 сарын 5 нд Дэлхийн гарын эрүүл ахуйн өдрийг тэмдэглэх аяны хүрээнд “Аюулгүй байдлын төлөө нэгдье: цэвэр гар” уриан дор дараах арга хэмжээг зохион байгууллаа.Тархвар судлаач Г.Долгорсүрэн, Нийгмийн ажилтан Х.Хэрлэн, Хүүхдийн тасгийн ахлах сувилагч Х. Эрдэнэтуяа нар хамтран "Гараар дамжих халдвар, гарын ариун цэвэр" сэдэвт сургалтыг зохион байгуулж. Хэвтэн эмчлүүлэгчдэдээ Black box ашиглан гараар халдвар хэрхэн дамжихыг бодитоор үзүүлж мөн гар угаах дарааллыг харуулсан богино хэмжээний 2 видео үзүүлж, гар угаах дарааллыг гардан зааж сургалаа. 2022 оны 10сарын15нд Дэлхийн гар угаах өдрийг тохиолдуулан Хүүхдийн тасаг тасгийнхаа болон клиникийн тасгийн хэвтэн эмчлүүлэгч,сахиур нарт гар угаах зөв аргыг зааж сургалт зохион байгуулж, үйлчлүүлэгчдэд мэдээ мэдээллээр хангаж ажилласан.
120	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67	1.1.г/. цар тахлаар өвдөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа болон гэрийн тусгаарлалтад байгаа иргэдэд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл дутмагаас шалтгаалан өвчин хүндрэх, амь нас нь эрсдэх аюулаас урьдчилан сэргийлэх, цар тахлын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжийг бүрдүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)		Хэвтэн эмчлүүлэх тасагт 71 КОВИД 19 батлагдсан тохиолдлын хүндрэх эрсдэлтэй хөнгөн болон, хүндэвтэр биеийн байдалтай өвчтөнг эмчлэн гаргаж, энгийн тасагт хэвтэн эмчлүүлж байсан 2 үйлчлүүлэгчээс коронавирусын халдвар илэрч ХӨСҮТ рүү шилжүүлсэн. Коронавирус халдвартай холбоотойгоор дараах тоног төхөөрөмжийг хандиваар болон худалдаж авсан.Зөөврийн рентген аппарат -1 ширхэг, амьсгалын аппарат-2 ширхэг, Хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч аппарат -4 ширхэг, эмнэлгийн зориулалтын ор -38 ширхэг, мананцар үүсгэгч-2 ширхэг, автомакс хошуу тасгийг тоогоор, пульсоксиметр-эмчийн тоогоор ханган ажиллалаа. Эм эмнэлгийн хэрэгслийн тухайд хүндрэх эрсдэлтэй хөнгөн болон, хүндэвтэр биеийн байдалтай өвчтөнг эмчилгээг бүрэн хангаж гаднаас эм тариа даатгуулагчаас авчруулаагүй болно.
121		1.1.д/. халдвар авсан иргэдэд гэрийн тусгаарлалтад байх хугацаанд эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээг үнэн зөв, шуурхай хүргэх, өвчнийг эмчлэхэд		2022 оны 01 сарын 12 өдрийн А/16 дугаар тушаалын дагуу коронавирус халдвартай иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх 40 орыг 2022 оны 1 дүгээр сарын 17-нд нээн ажиллаж

		шаардлагатай эмийн төрөл, хэрэглэх тун, заавар, мэдээллээр бүх иргэнийг тэгш, хүртээмжтэй хангах; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	байсан. Тусламж үйлчилгээг нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй эмч, эмнэлгийн ажилчид ээлжээр ажиллаж ажлын хөлс илүү цагийг тооцож олгосон. Коронавируст халдварын батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэх хэсгийг халдвартай буюу улаан, халдварын эрсдэл дунд буюу шар, халдваргүй буюу ногоон гэсэн 3 бүсэд хувааж, тусгаарлалтыг зохион байгуулсан. Хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөх, аюулгүй тайлах, гарын эрүүл ахуй сахих, халдваргүйжүүлэх бодисыг зөв хэрэглэх, хог хаягдлын менежмент, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх зэрэг халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлийг баримтлан ажиллаж байна. Үйлчлүүлэгчийг гарахад халдвар хамгааллын талаар зөвлөгөө мэдээллийг байнга өгч ажиллаж байсан.
122		1.1.е/. цар тахлын голомтод ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг эрсдэлийн болон амь насны даатгалд хамруулах, даатгалын нөхөх төлбөр авах, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэгийг тогтмол үзүүлэх асуудлыг судлан, холбогдох арга хэмжээг авч, цар тахлын голомтод ажиллаж байгаа төрийн албан хаагчдын илүү цагийн урамшуулал, голомтын бүсэд ажилласан хугацаанд онцгой нэмэгдлийг ердийн үеэс 2 дахин нэмэгдүүлсэн хувь хэмжээгээр тооцож олгох асуудлыг судлан шийдвэрлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	Иргэдэд тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй ялгаварлан гадуурхахгүйгээр үзүүлсэн. КОВИД-19 шинжилгээг шаардлагатай тохиолдолд хийж, сөрөг гарсан тохиолдолд, тасагт хэвтүүлэх, эерэг тохиолдолд ХӨСҮТ-д шилжүүлэн эмчлүүлсэн ба 2022 оны жилийн эцсийн байдлаар 2 тохиолдол гарсан.
123		1.1.ё/. цар тахлын үед иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр шуурхай, баталгаатай эдлүүлэх бүх боломж нөхцөлийг бүрдүүлж, халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эсэхээс үл хамаарч төрийн үйлчилгээ авах эрхийг хязгаарлахгүй байх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар	Цар тахлын үед иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр шуурхай үзүүлсэн.

			тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	
	126		1.2.в/. (Бусад асуудлаар:) эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах, тоног төхөөрөмж, шаардлагатай бусад нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, эрүүл мэндийн салбарын эрсдэлийн үнэлгээг хийх, хариу арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;	Гамшгаас хамгаалах АӨСҮТ-ийн мэргэжлийн ангийн бүтэц нь 2021 оны 1 сарын 6 өдрийн захирлын тушаалаар шинэчлэн батлагдсан.2020 оны галын аюулгүй байдлын дүгнэлт дууссан тул, сунгах хүсэлт өгсөн тул 2021 оны 11 сарын 15- 2023 оны 11 сарын 15 хүртэл 2 жилээр сунгуулсан. 2021 оны 1 сард АӨСҮТ-н гамшгаас төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан.
УИХ-ын байнгын хорооны тогтоол				
30	146	Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ	2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах;	Тус төв нь эмчилгээ, үйлчилгээний тоон мэдээ, мэдээллийн бааз үүсгэх, мэдээллийг нэгтгэн, тайлагнах, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх зэргээр эмнэлгийн статистикийн үйл ажиллагааг эрхэлдэг. ЭМХТөвд сар бүр хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн мэдээг 20 үзүүлэлтээр мөн халдварт өвчний өвчлөл, нас баралтын мэдээг 4 үзүүлэлтээр тус бүр гарган тайлагнадаг. Жилийн эцсийн статистик үзүүлэлтэд: -АӨСҮТ-н үйл ажиллагааны тайлан ЭМТ-201 -Хүний нөөцийн тайлан ЭМТ-401 -АӨСҮТ-н хүчин чадлын тайлан ЭМТ-402 -Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн тайлан ЭМТ-501 -АӨСҮТ, кабинетуудын үйл ажиллагааны ЭМТ-311 тайлангуудыг явуулдаг. АӨСҮТ, кабинеуудын үйл ажиллагааны тайланд аймаг, дүүргийн эмнэлгүүдийн арьсны кабинетуудын амбулаторийн үзлэг, диспансерийн үзлэг,урьдчилан сэргийлэх үзлэг, арьсны кабинетуудын диспансерийн хяналт, арьсны кабинетуудын диспансерийн хяналт /насны ангиллаар/, диспансерийн хяналтын өвчтөнд үзүүлсэн стационар, амбулаторийн тусламж, арьсны халдварт өвчний хяналт гэсэн үзүүлэлтүүдээр нэгтгэн тайлагнадаг. Сар бүр ЭМХТөвд тус төвийн тусламж үйлчилгээний статистик үзүүлэлт, мэдээ тайланг илгээдэг бөгөөд ЭМХТөвөөс

				статистик үзүүлэлтэнд тулгуурлан эргэн мэдээлэл хийж хамтран ажиллаж байна. ЭМЯ-ны https://burtgel.mohs.mn/ системд өдөр бүр /яаралтай тусламжаар ирсэн үйлчлүүлэгчийн тоо, хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчийн тоо, эмнэлгийн амьсгалын аппарат болон төхөөрөмжийн тоо г.м/ тоон мэдээллүүдийг өгч ажилладаг бөгөөд энэ системээс бүх эмнэлгийн яаралтай тусламж, хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдийн тоон мэдээллийг нэгдсэн байдлаар гаргах боломж бүрдэж байгаа.
Ерөнхийлөгчийн зарлиг				
38	165	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/ 2020-02-12 Дугаар 2020_10	1. 1. Дэлхийн олон улс болон манай хөрш БНХАУ-д шинэ коронавирусийн тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл болгосугай: 1.1. Шинэ коронавирусийн тархалтын нөхцөл байдалтай уялдуулан хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэглэлийг үе шаттайгаар сонгон хэрэгжүүлэх шийдвэр гаргах; 1.2. Олон улсын хөл хориот болон халдварт бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин гарсан үед тархаахгүй байх, таслан зогсоох зорилгоор хорио цээрийн дэглэм тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар яаралтай хэлэлцэн журамлаж, мөрдүүлэх; 1.3. Цагаан сарын баярт зориулсан олон нийтийг хамруулсан үзэсгэлэн худалдаа, мэдээллийн хэрэгслээр явуулах реклам, сурталчилгааг даруй зогсоох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх иргэдийн үүрэг, хариуцлага, уг халдварын хор хөнөөлийг ухуулан ойлгуулах ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион	2022 оны 01 сарын 12 өдрийн А/16 дугаар тушаалын дагуу коронавирус халдвартай иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх 40 орыг 2022 оны 1 дүгээр сарын 17нд нээн ажиллаж байсан. Тусламж үйлчилгээг нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй эмч, эмнэлгийн ажилчид ээлжээр ажиллаж байна. Коронавируст халдварын батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэх хэсгийг халдвартай буюу улаан, халдварын эрсдэл дунд буюу шар, халдваргүй буюу ногоон гэсэн 3 бүсэд хувааж, тусгаарлалтыг зохион байгуулсан. Хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөх, аюулгүй тайлах, гарын эрүүл ахуй сахих, халдваргүйжүүлэх бодисыг зөв хэрэглэх, хог хаягдлын менежмент, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх зэрэг халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлийг баримтлан ажиллаж байна. Үйлчлүүлэгчийг гарахад халдвар хамгааллын талаар зөвлөгөө мэдээллийг байнга өгч байна. Эмч эмнэлгийн ажилчид батлагдсан тохиолдолтой хавьтал болох эрсдэл өндөр байгаа тул байнга тандалт хийж байна. Мөн ажилчид болон хэвтэн эмчлүүлэгчийг 7 хоногт 3 удаа ПГУ/PCR/-ийн шинжилгээнд хамруулж байна. 2022 оны 1 сард нийт-628 шинжилгээ авсан байна. Үүнээс: • Хэвтэн эмчлүүлэгч- 318 Батлагдсан тохиолдол-3 /хүүхэд-1, 1,2-р тасаг-2/ • Ажилчид-241 /давхардсан тоогоор/ Батлагдсан тохиолдол-43/ • Сайн дураараа-69 2022 оны 2 сард нийт-311 шинжилгээ авсан байна. Үүнээс: • Хэвтэн эмчлүүлэгч- 217 Батлагдсан тохиолдол-1 /ЭЭЯТТ-1 /

			<p>байгуулах; 1.4. Дэлхий дахинд хүнээс хүнд, мал, амьтнаас хүнд халдварлах халдварт өвчин ихээр тархах болсонтой холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай болон бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулган, шаардлагатай бол ээлжит бус чуулганаар яаралтай горимоор хэлэлцүүлэх.</p> <p>2. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүргээ ухамсарлан, өөрийн болон нийтийн эрх ашгийг эрхэмлэхийг нийт ард иргэдэд уриалсугай.</p>	<ul style="list-style-type: none"> • Ажилчид-69 /давхардсан тоогоор/ Батлагдсан тохиолдол-8/ • Сайн дураараа-23 <p>2022 оны 3 сард нийт-190 шинжилгээ авсан байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> • Хэвтэн эмчлүүлэгч- 166 Батлагдсан тохиолдол-0 • Ажилчид-21 /давхардсан тоогоор/ Батлагдсан тохиолдол-3/ • Сайн дураараа-3 <p>2022 оны 2 сарын 9нд коронавирус халдвартай хэвтэн эмчлүүлэгчийн ор буулгах шийдвэрийн дагуу улаан бүсийг буулгасан. Улаан бүсийг буулгахад ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээ, угаалгыг нэг бүрчлэн халдвар хамгааллын дэглэм баримтлан хийж, арьсны тусламж үйлчилгээг үзүүлэхэд бэлэн болсон.</p> <p>2022 оны 4 дүгээр сараас эхлэн ковид-19 халдварын пгу шинжилгээг зогсоож, хэвтэн эмчлүүлэгч болон ажилдыг антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ авч эрсдэлээс сэргийлж байна.</p> <p>4-9 саруудад нийт 1609 антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ авсан байна.</p> <p>Коронавирус халдвараас сэргийлэх арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу /амны хаалтыг 2 цаг тутамд солих/ эмнэлгийн ажилчдад өдөрт 4 ширхэг маск тарааж байна. • Халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор жавьлионы 0.06%-ийн процентоор найруулан эмнэлгийн халдваргүйтгэлийг өдөр бүр хийж байна. Үйлчлүүлэгчийн бөөгнөрөл ихтэй лаборатори, амбулатори, зээтт-т 2 цаг тутам агаарын мананцар үүсгэгчээр халдваргүйжүүлэлт хийж байна. • Ажилчдын дархлааг дэмжих зорилгоор 1, 3, 5 дахь өдрүүдэд халуун аарц, чацаргана, үзэмний шүүсээр хангаж байна. • Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцөлийг өдөр бүр бүрдүүлж ажиллаж байна. • Коронавирус халдварын мэдээ мэдээллүүдийг эмнэлгийн дотоод хуудсанд байршуулж мэдээллээр хангаж байна. • Долоо хоног бүрийн Мягмар гаригт ХӨСҮТ болон ЭМЯ-аас зохион байгуулж байгаа тандалт хариу арга хэмжээний сургалтад сууж, ажилчдыг мэдээ мэдээллээр хангаж байна.
--	--	--	--	---

	170	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Архидан согтууруулахаас сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрийн хүрээнд. Арьс харшлын өвчинд үзүүлэх архины хор нөлөө сэдвээр их эмч Н.Ням-олдох иргэдэд мэдээлэл хийж байгууллагын пэйж болон амбулаторийн ТВ гээр дамжуулан мэдээлэл хүргэлээ. Амбулатори, хэвтэн эмчлүүлж буй иргэдэд архины харшил, архи согтууруулахаас ундаа хүний бие махбодод үзүүлэх хор хөнөөл, арьсанд үзүүлэх архины хор уршгийн талаар мэдээлэл хүргэж ажиллаа.
ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл				
46	188	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03	6. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга)	Гамшгаас хамгаалах АӨСҮТ-ийн мэргэжлийн ангийн бүтэц нь 2021 оны 1 сарын 6 өдрийн захирлын тушаалаар шинэчлэн батлагдсан. 2020 оны галын аюулгүй байдлын дүгнэлт дууссан тул, сунгах хүсэлт өгсөн тул 2021 оны 11 сарын 15- 2023 оны 11 сарын 15 хүртэл 2 жилээр сунгуулсан 2021 оны 1 сард АӨСҮТ-н гамшгаас төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан. 2022 оны 03 сарын 24-ний Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх өдрийн хүрээнд АӨСҮТ идэвхтэй оролцсон. Нийт 154 хамрагдсан.
ЗГ-ын тогтоол				
48	191	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ	Монгол улсын иргэний боловсрол сургах-судлах-сурталчлах төв ТББ-тай хамтран сургалтын хөтөлбөрийг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд эхний ээлжид удирдах албан тушаалтнуудыг хамруулах үйл ажиллагааг онлайн болон цахим хэлбэрээр II-р улиралд багтаан хийх болсон. Цаашид Байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж хэвшүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

			<p>тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;</p> <p>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;</p> <p>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>	
200	<p>Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448</p>	<p>2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:</p> <p>2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;</p> <p>2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;</p> <p>2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах;</p> <p>2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах;</p> <p>2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем</p>	<p>2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу эмнэлгийн байгууллагууд хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд эмчилгээ эрхэлсэн дэд захирал, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал гэсэн 2 орон тоотой ажиллаж байна.</p> <p>2.2 хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг өмнөх оны 7-р сарын 20-ны дотор багтаан ЭМЯ-нд хүргүүлдэг.</p> <p>2.3 төсөл арга хэмжээний мөн сургалт семинар хурал зөвлөгөөн хийгээгүй болно.</p> <p>2.4 Томоохон урсгал зардлын ажлыг хийгээгүй бөгөөд техник эдийн засгийн үндэслэл боловсруулаагүй тул үүнтэй холбоотой хөрөнгө төсвөөс зарцуулаагүй.</p>	

			(PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл				
73	220		XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	Төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагын дагуу E-health программыг хэрэглэж байгаа ба энэ программ нь байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээний эхний үе шат юм. Мөн утсаар үзлэгийн цаг авах, шинжилгээний хариуг автомат төхөөрөмжөөс гаргах файлаар илгээх, телемедицин /зайн оношлогоо/ хөгжүүлэх зэрэг нь мөн болно.
	224		XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглэнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	2022 оны 05 сард МОНПАСС компаниас гүйцэтгэх захирал болон санхүүгийн албаны дарга нар цахим тоон гарын үсэг авсан. Хэрэгжүүлж ажиллаж байгаа ба байгууллагын и-монголиа системээс мэдээллээ шалгаж туршсан. Мөн ЭМЯ-аас эмнэлгүүдийн цалинг цахим гарын үсгийн тусламжтай олгож байна.
	227		XIII.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл	Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх нь” сэдэвт сургалт, Хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настнуудад тулгарах орчны саадыг бууруулах зорилгоор 4 чиглэлийн замын доголыг засаж налуу байдлаар засварлаж, зориулалтын бариул,

		<p>2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33</p> <p>мэндийн сайд С.Энхболдод даалгав: 2.1. тархины саа, саажилт, уналт таталттай хүүхдийн уналт таталтын эсрэг эм хангамжийн нөхцөл байдлыг судалж, шаардлагатай эм, бэлдмэлийг бүртгэлжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх, төлбөрийг төрөөс хариуцах эмийн жагсаалтад оруулах, яаралтай горимоор хангах талаар холбогдох арга хэмжээ авах; 2.2. ховор тохиолддог өвчин, эмгэгийг эмчлэх болон гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, нөөц, бэлэн байдлын асуудал хариуцсан байгууллагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгуулах эсэх асуудлыг судалж саналаа Засгийн газарт танилцуулах; 2.3. хүүхдийн өвчин, эмгэг, хавдар, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн тархвар зүй, шалтгаан, хэрэгцээний талаар судалгаа хийж, өвчин, эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, эмчийн хандлага, харилцаа, эмийн болон бусад эмчилгээг олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 2.4. бүх шатанд хүүхдийн мэдрэлийн эмгэгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмчилгээ, үйлчилгээний үр дүнг үнэлэх, нарийн мэргэжлийн эмчийг чадавхжуулах талаар зохих арга хэмжээ авах; 2.5. Монгол Улсад эмчлэх боломжгүй хүүхдийн өвчин, эмгэгийг гадаадын эмчилгээний багтай хамтран эх орондоо эмчлэх боломж, нөхцөлийг судалж, мөс засал яаралтай хийлгэх шаардлагатай зарим хүүхдийн асуудлыг 2022 оны 9 дүгээр сард багтаан нэн тэргүүнд шийдвэрлэх, эмчилгээний арга технологийг нутагшуулах замаар эмнэлгийн</p>	<p>тэргэнцэр байршуулсан. 2022 онд байгууллагын авто машины зогсоолын тохижуулах ажлыг эхлүүлэн ажиллуулж байна. Тус төв нь хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч нарт зориулж эрүүл мэндийн чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны материалыг брайль үсгээр хэвлүүлэн цахим бүртгэлийн хэсэгт байршуулж, иргэдийг очер дугаар харгалзалгүй үйлчилгээг үзүүлж байна. Мөн угтах үйлчилгээнд дохионы хэлтэй хөтчийг ажиллуулж байна.</p>
--	--	--	---

		<p>мэргэжилтнийг чадавхжуулах; 2.6. хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засахад шаардлагатай хүний нөөц, оношилгооны лаборатори, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо судалгааг гаргаж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах.</p>	
243	<p>2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58</p>	<p>XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;</p>	<p>Төрийн байгууллага хооронд цахимаар албан бичих солилцохдоо able программыг ашиглаж байна.</p>